



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2021. 04. 23 № 18

Асуулга тавих тухай

Монгол Улсад Коронавируст цар тахал өдрөөс өдөрт мянга мянгаар нэмэгдэж, нас баралт 60 гарсан байна. Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв ачааллаа дийлэхгүй, эмч, эмнэлгийн ажилтнууд өдөр, шөнөгүй ажиллаж байгаа ч сүүлийн үед тэдний холбогдсон гэх асуудлууд ар араасаа гарсаар байгаа нь нийгмийг цочирдуулж, талцуулаад байна.

Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан 2021 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвийн нэр бүхий эмч, ажилтнууд 80 мянган төгрөгөөр шинжилгээний хариуг солих, бусдын өмнөөс шинжилгээ авах зэрэг зөрчил гаргасан талаар мэдээлсэн.

Түүнчлэн Эрүүгийн Цагдаагийн газар болон Тагнуулын байгууллагаас Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвд хийсэн хяналт, шалгалтаар тусгай үүргийн нислэгээр явсан 6000 орчим иргэн шинжилгээний төлбөр төлсөн бөгөөд хуримтлагдах ёстой 900 орчим сая төгрөгөөс 400 гаруй сая төгрөг Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвийн дансанд хуримтлагдсан талаар болон тус төвийн эмч, ажилтан болох С гэгч 21260, М гэгч 18328 удаа, Н гэгч нь 8483 удаа тус тус эрүүл.гэрэгэ.мн /eruul.gerege.mn/ системээр нэвтэрч, иргэдийн шинжилгээний хариуг засварлаж хувьдаа их хэмжээний хөрөнгө завшсан гэх эмч, эмнэлгийн ажилтнуудыг буруутгасан мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаад байна.

Цар тахлын нөхцөл байдал хүнд байгаа энэ цаг үед халдварт өвчинтэй тэмцэх тэргүүн эгнээнд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилтнууд Коронавирусийн халдварыг тараасан мэт ойлголт төрөхүйц мэдээлэлтэй холбогдуулж Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд үүсээд байгаа нөхцөл байдалтай холбогдуулж дараах асуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд Танд хандан тавьж байна.

2020000163